

- Кейс судалгаанд зориулсан оюутны дасгал ажлын хуудас - Т. Парк дах лаг боловсруулалт



Ногоон ур
чадвар

Танин мэдэхүйн чадварууд:

- Ногоон сорилтыг шийдэх шинэ стратегийг бий болгох, шинэ боломжуудыг олж илрүүлэх ур чадвар
- Тогтвортой хөгжлийн асуудал, сорилтуудын нарийн төвөгтэй байдал, харилцан уялдаа холбоог ойлгох

Хувь хүний дотоод чадварууд:

- Ажилтныг ажлын байраа ногоон болгоход шаардлагатай шинэ технологи, үйл явцыг сурч, хэрэгжүүлэхэд туслах дасан зохицох, хөрвүүлэх чадвар

Технологийн ур чадвар:

- Удирдлагын систем (хог хаягдал, эрчим хүч, ус)



Сургалтын
зорилго

Та энэхүү хичээлээр:

1. Эргэх холбоо бүхий эдийн засаг дах "хог хаягдлыг ашиглах боломжтой болгох" зарчмыг ойлгох
2. Эргэх холбоо бүхий загвар руу шилжихийн тулд өөрийн сонгосон салбарт ямар өөрчлөлт хийж болохыг тодорхойлох



Сургал явуулах
хэлбэр

Бие даан сурах, танилцах аялал



Ашиглагдах
материал

Оюутны дасгал ажлын хуудас, А4 хэмжээтэй бичгийн цаас



Хугацаа

Танхимд 30 минут; танилцах аялал – хагас өдөр




Үнэлгээ

Дараах зүйлд үндэслэн таныг үнэлнэ:

Танилцах аяллын тайлан (оюутан бүр тайлан бэлдэх бөгөөд хар зураг болон гэрэл зураг оруулсан, 1500 хүртэлх үгтэй тайлан байна) дээр үндэслэн үнэлгээ өгнө

Танилцах аяллын өмнөх бэлтгэл хичээл (танхимаар):

1. Багаар ярилцах
 - a. Кейс судалгааг сайтар уншаад Т.Парк нь хэрхэн эргэх холбоо бүхий үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж болохыг тунгаагаарай. (сэдвийн мэдээллийн хуудсыг уншина уу)
 - b. а асуултыг багынхантайгаа ярилцана уу.
2. Багаараа танилцах аяллаа төлөвлөх
 - a. Т. Park-д болох гэж буй үйл ажиллагаа эсвэл семинаруудыг шалгаад, бүлгийнхээ оролцохыг хүсч буй ядаж нэг үйл ажиллагааг сонго (жишээ нь, бетон өсгөгчийн ангид суух). Онлайнаар бүртгүүлээрэй.
 - b. Багаараа оролцож буй үйл ажиллагаанаас гадна Т. Парк дахь Т. кафе, Т. театр, Т. дээвэр зэрэг өөр өөр байгууламжуудаар зочлоорой.



Танилцах аяллын үеэр:

1. Танд сэтгэгдэл төрүүлсэн зүйлсийн зургийг авч, дэвтэртээ товч тэмдэглэл хийгээрэй.
2. Өөрийн сонгосон салбарт ашиглагдаж болох “**хаягдлаас эрчим хүч**” эсвэл “**хог хаягдлыг ашиглах боломжтой болгох**”-той холбогдох дор хаяж хоёр санаа юм уу хоёр загварыг олоорой.
3. Багтайгаа өөрийн бодлоо хуваалцаж, эдгээр санааг хамтдаа ярилцаарай.



Танилцах аяллын дараа:

Доор дурдсан зүйлсийг оролцуулан танилцах аяллын тайлангаа хийнэ үү:

1. Оролцсон үйл ажиллагааны тайлбар, өөрт төрсөн сэтгэгдэл, санаа: Та юу сурсан бэ? Танд юу сонирхолтой санагдав?
2. Өөрийн зочилсон байгууламжуудын мэдээлэл, тэдгээр нь эргэх холбоо бүхий загварын ямар талуудтай холбоотой талаар таны эргэцүүлэл (сэдвийн мэдээллийн хуудсыг үзнэ үү).
3. **Хог хаягдлыг эргэх холбоонд оруулж ахин ашиглах зүйл болгохын** тулд аяллаас олж мэдсэн санаагаа ашиглан өөрийн сонгосон салбарт ямар өөрчлөлт хийж болох талаар багаараа хийсэн ярилцлагын үр дүн.

Эх сурвалж:

Story | T · PARK. Retrieved from <https://www.tpark.hk/en/story/>